



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/569.

Улаанбаатар хот

### 「Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 259」 дүгээр цэцэрлэгийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эцэг эхчүүдээс хандивласан нийт 2,935,000.00 (хоёр сая есөн зуун гучин таван мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Сонгинохайрхан дүүргийн 259 дүгээр цэцэрлэг (Ц.Батцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 259 дүгээр цэцэрлэг (Ц.Батцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 10 өдрийн А/69 дугаар тушаалын хавсралт

Бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 259 дүгээр цэцэрлэг

| №                      | Эд хөрөнгийн нэр      | Ашиглалта нд орсон | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэх үнэ |              | Хандив      | Эх үүсвэр |
|------------------------|-----------------------|--------------------|--------------|-------------|------------|-------------|--------------|-------------|-----------|
|                        |                       |                    |              |             |            | Нэгжийн үнэ | Нийт үнэ     |             |           |
| 1                      | Ус цэвэршүүлэгч       | 2024               | сайн         | ш           | 1          | 245,000.00  | 245,000.00   | Эцэг эхчүүд | Хандив    |
| 2                      | Зурагт 55 инч samsung | 2024               | сайн         | ш           | 1          | 850,000.00  | 850,000.00   |             |           |
| 3                      | Зурагт 55 инч samsung | 2024               | сайн         | ш           | 1          | 890,000.00  | 890,000.00   |             |           |
| 4                      | Зурагт 55 инч samsung | 2024               | сайн         | ш           | 1          | 950,000.00  | 950,000.00   |             |           |
| Тоног төхөөрөмжийн дүн |                       |                    |              |             |            |             | 2,935,000.00 |             |           |
| Нийт дүн               |                       |                    |              |             |            |             | 2,935,000.00 |             |           |